

ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Төлбөрийн үйлчилгээний журмын зорилго нь (цаашид “журам” гэх) “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (цаашид “ҮЦТХТ” гэх) нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу арилжааны төлбөр гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэх, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлох, төлбөрийн гишүүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нэр томъёо

- 2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно.
 - 2.1.1. “Арилжаа эрхлэх байгууллага” (цаашид Бирж гэх) гэж ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
 - 2.1.2. “Арилжааны төлбөр тооцооны байгууллага” (цаашид АТТ гэх) гэж ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
 - 2.1.3. “Оролцогч” гэж Төлбөрийн гишүүнээс бусад Үнэт цаасны компани, Кастодиан банкыг;
 - 2.1.4. “Төлбөр” гэж “ҮЦТХТ” нь үнэт цаасыг шилжүүлэх болон түүний төлбөрийг эцэслэн гүйцэтгэх үйл явцыг;
 - 2.1.5. “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт” гэж үнэт цаасны төлбөр хийгдсэн тохиолдолд үнэт цаас шилжүүлэх баталгааг;
 - 2.1.6. “Төлбөрийн гишүүн” гэж “ҮЦТХТ”-ийн зөвшөөрлөөр энэ журмын дагуу төлбөр гүйцэтгэх этгээдийг;
 - 2.1.7. “Төлбөр гүйцэтгэх өдөр” гэж арилжаа явагдсанаас хойш ажлын 2 хүртэлх өдрийг;
 - 2.1.8. “Төлбөр эцэслэх цаг” гэж үнэт цаасны төлбөр гүйцэтгэж эцэслэх цагийг;

- 2.1.9. “Төлбөр зуучлагч банк” гэж төлбөрийн гишүүний нэрийн өмнөөс мөнгөн төлбөрийг төлж, хүлээж авах банк;
 - 2.1.10. “Төлбөрийн гишүүний данс” гэж төлбөрийн гишүүн төлбөр гүйцэтгүүлэх зорилгоор “ҮЦТХТ” дээр нээлгэсэн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаас шилжүүлэх дансыг;
 - 2.1.11. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн төлбөрийн данс” (цаашид Төлбөрийн данс гэх) гэж “ҮЦТХТ”-өөс төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд ашиглах дансыг;
- 2.2. Энэхүү журамд тайлбарлаагүй нэр томъёог Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль журамд тайлбарласантай ижил утгаар ойлгоно.

Гурав. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчим

- 3.1. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийг ҮЦЗЗ тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2 дугаар хэсгүүдэд зааснаар хийж гүйцэтгэнэ.
- 3.2. “ҮЦТХТ” нь төлбөрийн гишүүний дансанд зохих мөнгөн төлбөр болон үнэт цаасыг байршуулснаар төлбөр эцэслэгдэнэ.
- 3.3. Мөнгөн төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлийг АТТ-ны “Үнэт цаасны клирингийн журам”-аар зохицуулна.

Дөрөв. Төлбөр гүйцэтгэх хугацаа

- 4.1. Төлбөр гүйцэтгэх хугацаа нь төлбөр гүйцэтгэх өдрийн 09:15 цагаас 11:00 хүртэл байна.
- 4.2. “ҮЦТХТ” нь шаардлагатай тохиолдолд энэ журмын 4.1-т заасан төлбөр гүйцэтгэх хугацааг өөрчилж болох бөгөөд тухай бүр арилжаа эрхлэх байгууллага, арилжааны тооцооны байгууллага, төлбөрийн гишүүн болон “ҮЦТХТ”-ийн оролцогчдод урьдчилан мэдэгдэнэ.

Тав. Төлбөр эцэслэх хугацаа

- 5.1. Төлбөр эцэслэх хугацаа нь төлбөр гүйцэтгэх өдрийн 11:00 цаг байна.
- 5.2. Бирж, АТТ-ноос гаргасан хүсэлт болон өөр бусад шалтгаанаар “ҮЦТХТ”-өөс төлбөр эцэслэх хугацааг 1 цагаар сунгаж болно.
- 5.3. “ҮЦТХТ” нь дараах тохиолдлуудад төлбөр эцэслэх хугацааг өөрчилж болно.
Үүнд:
 - 5.3.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй болон үүнтэй дүйцэхүйц онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд;
 - 5.3.2. Төлбөр гүйцэтгэх системд төлбөрийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд;
- 5.4. “ҮЦТХТ” нь энэ журмын 5.1-т заасан төлбөр эцэслэх хугацаа өөрчлөгдсөн даруй Бирж, АТТ болон төлбөрийн гишүүнд мэдэгдэнэ.

Зургаа. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийг хэрэгжүүлэх банк

- 6.1. Мөнгөн төлбөр тооцоог Төв банкны төлбөрийн системээр дамжуулан хийж гүйцэтгэнэ.
- 6.2. Төв банк хуваарьт түр зогсолт хийж, төлбөрийн системийг төлбөр гүйцэтгэхэд ашиглах боломжгүй тохиолдолд “ҮЦТХТ” нь арилжааны банкуудаас төлбөр гүйцэтгэх банкыг сонгон төлбөрийн эсрэг нийлүүлэлтийг хийж гүйцэтгэнэ.

Долоо. Үйлчилгээний түр зогсолт

- 7.1. “ҮЦТХТ” нь Системийн саатал гэх мэт гарцаагүй байдлаас үүдэн үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд үйлчилгээгээ бүхэлд нь эсвэл хэсэгчлэн түр зогсоож болно.
- 7.2. Энэ журмын 7.1-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Бирж, АТТ, төлбөрийн гишүүн болон оролцогчдод нэн даруй мэдэгдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨЛБӨРИЙН ГИШҮҮН

Найм. Төлбөрийн гишүүнээр бүртгүүлэх, зөвшөөрөл олгох

- 8.1. Төлбөрийн гишүүнээр бүртгүүлэх этгээд нь “ҮЦТХТ”-ийн маягтын дагуу төлбөр гүйцэтгэх эрх авах хүсэлт гаргана. (Маягт 1)
- 8.2. “ҮЦТХТ” нь журмын 8.1-т заасан төлбөрийн гишүүнээр бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч ажлын 5 хоногт багтаан шалгаж, зөвшөөрсөн болон татгалзсан тухай шийдвэрийг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 8.3. АТТ-д гишүүнчлэлтэй клирингийн гишүүнийг энэ журмын 8.1 болон 8.2-т заасныг үл харгалзан АТТ-ны албан бичгийг үндэслэн төлбөрийн гишүүнээр бүртгэнэ.
- 8.4. “ҮЦТХТ” нь шинээр төлбөрийн гишүүнээр бүртгэсэн тухай бүр Бирж, АТТ болон төлбөрийн гишүүдэд мэдэгдэнэ.
- 8.5. Хүсэлт гаргагч нь төлбөрийн гишүүнээр бүртгэх шийдвэр гарсан өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн төлбөрийн гишүүний эрх үүснэ.
- 8.6. “ҮЦТХТ” нь төлбөрийн гишүүнээс тухайн байгууллагын санхүүгийн чадавхыг дүгнэх болон төлбөрийн үйл ажиллагааг саадгүй явуулах чадамжийг тодорхойлох зорилгоор санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан болон бусад холбогдох мэдээллүүдийг гаргуулан авч болно.

Ес. Төлбөрийн гишүүний шалгуур

- 9.1. Дараах шалгуурыг хангаж, нөхцөлийг зөвшөөрсөн этгээдийг Төлбөрийн гишүүнээр элсүүлнэ Үүнд:

- 9.1.1. СЗХ-ны холбогдох журмын дагуу зохицуулалттай этгээдээр бүртгэгдсэн байх;
- 9.1.2. “ҮЦТХТ”-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан Үнэт цаасны компани байх;
- 9.1.3. Хүсэлт гаргагч нь төлбөрийн гишүүний хувьд төлбөрийн үйлчилгээг найдвартай гүйцэтгэх хангалттай төлбөрийн чадавхтай байх;
- 9.1.4. Төлбөрийн гишүүний хувьд төлбөрийн үйлчилгээг үзүүлэхэд хангалттай боловсон хүчин, програм хангамж, техник тоног төхөөрөмж болон бусад тоног төхөөрөмжтэй байх;
- 9.1.5. Төлбөрийн чадваргүйд тооцогдсон эсхүл онцгой нөхцөл байдлын тохиолдол бий болоогүй байх;

Арав. Төлбөрийн гишүүний эрх, үүрэг

- 10.1. Төлбөрийн гишүүн нь төлбөр эцэслэгдсэн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “ҮЦТХТ”-өөс тухай бүр авах эрхтэй.
- 10.2. Төлбөрийн гишүүн нь үнэт цаас болон мөнгөн төлбөрийг гуравдагч этгээдийн дансаар хүлээн авах бол “ҮЦТХТ”-д мэдэгдэж зөвшөөрөл авна.
- 10.3. Төлбөрийн гишүүн нь журмын 9 дүгээр зүйлд заасан шаардлагуудыг биелүүлнэ.
- 10.4. Төлбөрийн гишүүн нь төлбөрийн үйл ажиллагааг хариуцах нэг ба түүнээс дээш ажилтан болон хяналт тавих ахлах ажилтанг томилж “ҮЦТХТ”-д бүртгүүлнэ.
- 10.5. Төлбөрийн гишүүн нь дараах тохиолдолд “ҮЦТХТ”-д нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:
 - 10.5.1. Дахин хөрөнгөжүүлэлтийн үйл ажиллагааг эхлүүлсэн;
 - 10.5.2. Төлбөрийн гишүүний эсрэг дампуурлын хэрэг үүсгэсэн;
 - 10.5.3. Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг үүсгэсэн, дуусгасан шийдвэр гарсан;
 - 10.5.4. Төлбөрийн гишүүний үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүчингүй болсон эсхүл үйл ажиллагаа нь зогссон;
- 10.6. Төлбөрийн гишүүн нь холбогдох хууль, журмын дагуу “ҮЦТХТ”-өөс авч буй арга хэмжээг дагаж мөрдөнө.

Арван нэг. Гишүүнчлэлээс түдгэлзүүлэх, хасах

- 11.1. Төлбөрийн гишүүн нь гишүүнчлэлээс өөрийн саналаар гарах тохиолдолд “ҮЦТХТ”-ийн маягтийн дагуу хүсэлт гарах бөгөөд хасах шийдвэрийг “ҮЦТХТ” гаргана. (Маягт 2)
- 11.2. “ҮЦТХТ” нь дараах тохиолдолд төлбөрийн гишүүнийг гишүүнчлэлээс хасах шийдвэр гаргана. Үүнд:

- 11.2.1. АТТ-ны клирингийн гишүүнээс гарсан;
- 11.2.2. Төлбөрийн гишүүний данс хаагдсан;
- 11.2.3. Татан буугдсан, дампуурсан;
- 11.3. “ҮЦТХТ” нь төлбөрийн гишүүнээс хассан тухай бүр Бирж, АТТ болон төлбөрийн гишүүдэд мэдэгдэнэ.
- 11.4. “ҮЦТХТ” нь дараах тохиолдолд төлбөрийн гишүүний гишүүнчлэлийг түдгэлзүүлж болох бөгөөд төлбөрийн гишүүнд урьдчилан мэдэгдэнэ. Үүнд:
 - 11.4.1. Журмын 10.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд;
 - 11.4.2. Журмын 9-д заасан шалгууруудыг хангаагүй;
- 11.5. Журмын 11.1-д заасны дагуу төлбөрийн гишүүн нь гишүүнчлэлээс гарах хүсэлт гаргасан болон 11.2-д заасны дагуу “ҮЦТХТ”-өөс гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн аль ч тохиолдолд “ҮЦТХТ” нь АТТ болон бусад төлбөрийн гишүүдэд мэдэгдэнэ.
- 11.6. “ҮЦТХТ” нь гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд төлбөрийн гишүүний хүсэлтийг үндэслэн гишүүнчлэлийг сэргээх эсэх шийдвэрийг гаргана.
- 11.7. Төлбөрийн гишүүнчлэлээс гарах хүсэлтийг “ҮЦТХТ” зөвшөөрсөн өдөр гишүүнчлэлээс гарсанд тооцно.
- 11.8. Төлбөрийн гишүүн нь төлбөрийн үүргийг дуусгавар болгоогүй бол гишүүнчлэлээс гарах хүсэлтийг гарахгүй. Эцэслэгдээгүй төлбөр байгаа тохиолдолд төлбөр эцэслэгдсэн өдрийг гишүүнчлэлээс хассан өдрөөр тооцно.

Арван хоёр. Төлбөрийн данс нээх

- 12.1. Төлбөрийн гишүүн бүр нь “ҮЦТХТ”-д өөрийн төлбөрийн гишүүний дансыг нээлгэнэ.
- 12.2. Төлбөрийн гишүүн нь Төв банкнаас тавигдах шаардлагыг хангаж Төв банкинд данс нээлгэж болно.
- 12.3. Төв банк хуваарьт түр зогсолт хийх үед ашиглах “ҮЦТХТ”-өөс тогтоосон төлбөрийн эсрэг нийлүүлэлтийг хэрэгжүүлэх арилжааны банкинд төлбөрийн гишүүний төлбөрийн данс нээлгэнэ.
- 12.4. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийг хэрэгжүүлэх арилжааны банкинд нээсэн дансыг зөвхөн Төв банкны төлбөрийн системийг ашиглах боломжгүй болсон тохиолдолд ашиглана.
- 12.5. Төлбөрийн гишүүний сонгосон төлбөрийн зуучлагч банк нь Төв банкинд өөрийн хөрөнгөөс тусдаа төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийх данс нээсэн тохиолдолд төлбөрийн данстай болсон гэж үзнэ.
- 12.6. Төв банк хуваарьт түр зогсолт хийхээр мэдэгдсэн тохиолдолд “ҮЦТХТ”-өөс аль арилжааны банкаар үйлчлүүлэх болсон талаар мэдээллийг төлбөрийн гишүүдэд урьдчилан мэдэгдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨЛБӨРИЙН ЭСРЭГ НИЙЛҮҮЛЭЛТИЙН /DVP/ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Арван гурав. АТТ-ноос ирүүлэх төлбөрийн даалгавар

- 13.1. АТТ нь дараах мэдээллийг агуулсан төлбөрийн болон үнэт цаас шилжүүлэх даалгаврыг боловсруулсан даруй ҮЦТХТ-д гаргаж өгнө. Үүнд:
 - 13.1.1. Төлбөр төлөгдөх огноо;
 - 13.1.2. Төлбөрийн гишүүн тус бүрээр төлбөр хийгдэх үнэт цаасны нэгдсэн дугаар, тоо хэмжээ;
 - 13.1.3. Төлбөрийн гишүүн тус бүрээр төлөгдөх мөнгөн төлбөрийн хэмжээ;
 - 13.1.4. Төлбөрийн үйлчилгээнд холбогдох шаардлагатай бусад мэдээлэл;
- 13.2. “ҮЦТХТ” нь журмын 13.1-т заасан төлбөрийн даалгавар АТТ-ноос хүлээж авсан даруй төлбөрийн гишүүнд мэдэгдэнэ.

Арван дөрөв. Төлбөрийн гишүүний төлбөрийн гүйцэтгэл

- 14.1. Төлбөрийн гишүүн нь төлбөрийн гишүүний дансанд тусгагдсантай ижил үнэт цаасны нэгдсэн дугаар, үнэт цаасны код бүхий үнэт цаасыг энэ журмын 4.1-т заасан хугацаанд багтаан “ҮЦТХТ”-ийн төлбөрийн дансанд байршуулна.
 - 14.1.1. “ҮЦТХТ” нь 14.1-т заасны дагуу төлбөрийн гишүүний дансанд байршуулсан үнэт цаасыг “ҮЦТХТ”-ийн төлбөрийн дансанд төлбөрийн өдрийн 09:15 цагаас эхлүүлэн автоматаар байршуулна.
- 14.2. Төлбөрийн гишүүн нь төлбөрийн болон үнэт цаас шилжүүлэх даалгаварт тусгагдсан мөнгөн төлбөрийг 12.2-т заасан дансанд байршуулна.
- 14.3. Төлбөрийн гишүүн нь Төв банкинд төлбөрийн данс нээлгээгүй бол төлбөрийн болон үнэт цаас шилжүүлэх даалгаварт тусгагдсан мөнгөн төлбөрийг “ҮЦТХТ”-ийн төлбөрийн гишүүний дансанд байршуулна.

Арван тав. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн мэдэгдэл

- 15.1. “ҮЦТХТ”-д дараах мэдэгдлийг төлбөр эцэслэхэд АТТ-д илгээнэ. Үүнд:
 - 15.1.1. Үнэт цаасны төлбөр эцэслэгдэхэд даалгаварт тусгагдсан мөнгөн төлбөрийг төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийх дансанд хийсэн мөнгөн төлбөрийн хэмжээ;
 - 15.1.2. Төлбөрийн үнэт цаасны шилжүүлсэн болон мөнгөн төлбөр гүйцэтгэсэн хугацаа;
 - 15.1.3. АТТ-д шаардлагатай бусад төлбөр тооцооны нэмэлт мэдээлэл;
- 15.2. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн баталгаажсан мэдэгдлийг “ҮЦТХТ” нь АТТ болон төлбөрийн гишүүн, оролцогчид хүргүүлнэ.

Арван зургаа. Саатсан төлбөр гүйцэтгэх үйл ажиллагаа

- 16.1. Төлбөрийн үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн төлбөрийн саатлын үед АТТ-ноос ирүүлсэн мэдэгдлийг үндэслэн гишүүний өмнөөс төлбөрийг гүйцэтгэсэн талд өмчлөх эрхийг шилжүүлнэ.
- 16.2. Үнэт цаас нийлүүлээгүйгээс саатсан төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг дараалсан хоёр арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
 - 16.2.1. Үргэлжилсэн төлбөр гүйцэтгэх (Continues net settlement)
 - 16.2.2. Худалдан авах замаар төлбөр гүйцэтгэх ажиллагааг эцэслэх
- 16.3. Үргэлжилсэн төлбөр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд дараах горимын дагуу ажиллана.
 - 16.3.1. “ҮЦТХТ” нь төлбөр эцэслэх цагт энэ журмын 15.1.1-т заасан мэдэгдлийг АТТ-д хүргүүлнэ.
 - 16.3.2. Төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг баталгаажуулахтай холбогдсон бусад шаардлагатай мэдээлэл;
- 16.4. АТТ нь энэ журмын 15.1.1-т заасан мэдэгдлийг хүлээн авсан даруйд баталгаажсан үргэлжилсэн төлбөр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд дараах дэлгэрэнгүй мэдээллийг “ҮЦТХТ” болон тооцооны гишүүдэд даруй мэдэгдэнэ.
 - 16.4.1. Төлбөрийн гишүүний байршуулаагүй үнэт цаасны тоо ширхэг;
 - 16.4.2. Төлбөрийн гишүүний хүлээн аваагүй үнэт цаасны тоо хэмжээ болон хүлээгдэж буй хугацаа (цаашид “Төлбөрийн гишүүн үнэт цаасыг хүлээн аваагүй тохиолдол” гэх);
 - 16.4.3. Үнэт цаасыг байршуулаагүй төлбөрийн гишүүн бүрээр шилжүүлээгүй үнэт цаасны оронд байршуулах шаардлагатай мөнгөн төлбөр (цаашид “ҮТГ мөнгөн төлбөр” гэх)-ийн хэмжээг;
 - 16.4.4. Үргэлжилсэн төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааны гүйцэтгэлтэй холбоотой шаардлагатай бусад мэдээлэл;
 - 16.4.5. Саатсан үнэт цаасны нийлүүлэлт түүний мөнгөн төлбөрийг 13.1-т заасан төлбөрийн даалгавраас хасаж шинэчлэн “ҮЦТХТ”-д ирүүлнэ.
- 16.5. “ҮЦТХТ” болон үнэт цаасыг байршуулаагүй төлбөрийн гишүүн нь 16.4-д заасан мэдээллийг баталгаажуулан хүлээн авч, үргэлжилсэн төлбөр гүйцэтгэх мөнгөн төлбөрийг дараах байдлаар бүрдүүлж төлбөрийг гүйцэтгэнэ.
 - 16.5.1. Төлбөр хийгдэх өдрийн 17:00 цагаас өмнө “ҮЦТХТ”-ийн төлбөрийн дансанд мөнгөн хөрөнгөөр эсвэл “ҮЦТХТ”-ийн зөвшөөрсөн бусад арга хэрэгслээр мөнгөн төлбөрийг байршуулна.
 - 16.5.2. “ҮЦТХТ”-ийн төлбөрийн данснаас төлбөрийн гишүүний дансанд ҮТГ-ийн мөнгөн төлбөрийг шилжүүлнэ.
- 16.6. Худалдан авах замаар төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг эцэслэх буюу энэ журмын 16.3-т заасны дагуу төлбөрийн үүрэг биелэгдээгүй бол “ҮЦТХТ” үнэт

цаас худалдан авах төлбөр гүйцэтгэх дараагийн арга хэмжээг авч доорх горимын дагуу ажиллана.

- 16.7. АТТ нь дараах мэдээллийг “ҮЦТХТ”-д хүргүүлнэ.
 - 16.7.1. Худалдан авах үнэт цаасны төлбөр хийх огноо;
 - 16.7.2. Худалдан авах үнэт цаасны тоо хэмжээг үнэт цаасны компани болон үнэт цаасны нэгдсэн дугаар тус бүрээр;
 - 16.7.3. Худалдан авалтад оролцох гишүүн бүрийн худалдан авалтын мөнгөн төлбөрийн хэмжээ;
 - 16.7.4. Худалдан авалтын төлбөр тооцоонд шаардлагатай бусад зүйлс.
- 16.8. “ҮЦТХТ”-д 16.7-д заасны дагуу худалдан авалтын дэлгэрэнгүй мэдээлэл хүргүүлсэн тохиолдолд төлбөрийг доорх байдлаар гүйцэтгэнэ.
 - 16.8.1. Худалдан авалтын гишүүн 16.7.1-т заасан өдрийн төлбөр эцэслэх хугацаанаас хэтрэлгүй худалдах үнэт цааснуудыг “ҮЦТХТ”-ийн төлбөрийн дансанд байршуулна. “ҮЦТХТ”-ийн төлбөрийн гишүүний дансанд саадгүй шилжүүлнэ.
 - 16.8.2. Үнэт цаасыг байршуулаагүй төлбөрийн гишүүн нь 16.7.1-т заасан өдрийн төлбөр эцэслэх цагт багтаан “ҮЦТХТ”-ийн төлбөрийн дансанд худалдан авалтын төлбөрийг байршуулна. “ҮЦТХТ”-ийн төлбөрийн дансанд худалдан авалтын төлбөр орсон даруй худалдан авалтын гишүүний төлбөрийн дансанд шилжүүлнэ.

Арван долоо. Нууцлал

- 17.1. “ҮЦТХТ”, АТТ, Төлбөрийн гишүүн, тэдгээрийн удирдах албан тушаалтнууд болон ажилтнууд, дээрх байгууллагуудын албан байранд нэвтрэхдээ хуулиар олгогдсоноос бусад нийтэд хаалттай, өөрсдийн ажил үүргийн хүрээнд олж авсан мэдээллийг өөрийн болон гуравдагч этгээдийн эрх ашгийн төлөө задруулах буюу ашиглахыг хориглоно.
- 17.2. Төлбөрийн гишүүн, болон удирдах албан тушаалтнууд аливаа мэдээ, мэдээллийг нууцлах үүрэг хүлээнэ.

Арван найм. Хариуцлага

- 18.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан болон оролцогчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн болон албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 18.2. Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

“Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-д төлбөрийн
гишүүнээр элсэх хүсэлт гаргагчийн өргөдөл

Огноо:

Хэнд: “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК

Чингэлтэй дүүрэг, 4 хороо, Самбуугийн гудамж,

Хэнээс: “-----” ----- компани

Бид өргөдлийн маягад туссан мэдээ, мэдээлэл, баримт бичгийг холбогдох хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-ийн журам, зааврын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа мэдээлэл орсон тохиолдолд бид хариуцлагыг хүлээнэ.

Түүнчлэн Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон “ҮЦТХТ” ХХК-ийн холбодох журам зааврыг мөрдөн ажиллах бөгөөд “ҮЦТХТ” ХХК-иас тавьсан шаардлагыг ханган ажиллах болно.

Иймд энэхүү өргөдөл, холбогдох баримт бичгийг хянаж, гишүүнээр элсэх зөвшөөрлийг олгоно уу.

Өргөдөл гаргагч:

Гүйцэтгэх захирал: _____

Гарын үсэг: _____

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн ерөнхий мэдээлэл	
Компанийн нэр	Байгуулагдсан он
Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар
Компанийн хаяг /олон салбартай бол төв салбарын хаягийг бичнэ/	
Аймаг, нийслэл	Сум дүүрэг
Дэлгэрэнгүй	
Компанийн утас	Цахим хуудас/ Цахим хаяг
СЗХ-ны тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл авсан огноо
Төлбөрийн гишүүний ангилал	
ҮЦТХТ-тай хамтран ажиллах гэрээний дугаар	Гэрээ байгуулсан огноо
Төлбөр хүлээн авах банкны нэр	
Төлбөр хүлээн авах дансны дугаар	

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ БОЛОН БОЛОВСОН ХҮЧНИЙ АНКЕТ

Огноо: 20__ оны __ сарын __


Овог: _____

Нэр: _____

Регистрийн дугаар: _____

Хүйс: эрэгтэй эмэгтэй

Албан тушаал: _____



Холбоо барих:

И-мэйл хаяг: _____

Гар утас: _____

Ажлын утас: _____

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн:

Дугаар: _____

Авсан он: _____

Дуусах он: _____

Төгссөн сургууль	Хаана	Мэргэжил	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар
Албан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан жил	Ажлаас гарсан шалтгаан	

_____ овогтой _____ нь дээрх мэдээллийг үнэн зөв мэдүүлснийг баталж байна.

Гарын үсэг: _____